

Ядуусын төлөөх Хөгжил гэж юу вэ?

*С. Мөнхчимэг, МУИС-ийн ЭЗС-ийн
Эдийн Засгийн Онолын 3-р ангийн оюутан*

Ядуус гэж хэн бэ? Энэ бол ямарваа нэг зүйлээр дутагдаж буй хүмүүс юм. Бусад хүмүүсээс ялгарах онцлог нь хомс байгаа зүйлийнхээ улмаас нэг зүйлээс татгалзахаас өөр аргагүйд хүрдэг. Хүний хөгжил гэдэг нь хүний боломжийг өргөсгөн чадавхийг сайжруулах процесс юм (1). Тэгвэл эндээс ядуус бол хөгжлийнхөө ямарваа нэг зүйлийг хангаж чадахгүй байгаа хүмүүс гэж тодорхойлж болохоор байна. Ядуусын төлөөх хөгжил гэдэг нь ядуусын боломжийг өргөтгөхийн тулд тэрхүү гачигдаж байгаа зүйлийг нь тэдэнд бий болгох, цаашлаад тэдгээрийн чадавхийг сайжруулаад тэгш байдлыг бий болгох процесс юм.

Ядуурал өөрөө маш олон хэлбэртэй. Эдгээрээс өнөөгийн нийгэмд газар аваад байгаа хамгийн хор уршигтай нь орлогын ядуурал юм. Монгол улсын хувьд эдийн засгийн өсөлт 2002 онд 4 хувь, 2003 онд 5.6 хувь, 2004 онд 10.6 хувь, 2005 онд 6.2 хувь, 2006 онд 8.4 хувьтай болж жилээс жилд өсөх хандлагатай байна. Гэвч ядуурлын түвшин 2000 онд 35.3 хувь, 2005 онд 36.1 хувь байснаа 2006 онд 32.2 хувь болж бага хэмжээгээр буурсан боловч ядуучуудын абсолют тоо нэмэгдсэн байна (2). Эндээс харахад хэдийгээр эдийн засаг өсөөд байгаа боловч өндөр инфляци болон эдийн засгийн ашигтай салбаруудад хэт их анхаарлаа хандуулснаас хүндээ өгөх үр өгөөж бага, ядуурал, нийгмийн тэгш бус байдал улам зузаатсаар байна.

Ядуучууд амьдралын наад захын хэрэгцээ болох хоол, хүнс, хувцас, орон байрны хэрэгцээгээ хангаж чадахгүйн дээр чадавхиа хөгжүүлэх боловсрол мэдлэг эзэмших хөрөнгө мөнгөний боломжгүй, амьдарлаа

сайжруулахын тулд зээл авах барьцааны хөрөнгөгүйгээс ямарваа нэг бизнес эрхлэх боломжгүй, зарим нь зээл авсан ч аж ахуй эрхлэх чадварын хомсдлоос болоод амьжиргаагаа сайжруулж чадахгүй байна. Үүний улмаас энэ байдалдаа гутарч архидан согтуурч, гэр бүлийн хүчирхийлэл гаргах, цаашлаад гэмт хэрэг хийж байна. Эндээс орлогын ядууралд өртөгсөд нь мэдээлэл мэдлэгийн ядуурал болоод харилцааны ядууралд өртөх үндсэн нөхцөл болж байгаа юм. Энд миний тодорхойлсон ядуурлууд нь доктор С.Баатар гуайн тодорхойлсон оюун санааны болоод харилцааны ядуурлаас бага зэрэг ялгаатай юм (2). Учир нь ядуу айлын бага балчир хүүхдүүд эргээд ажил хийж гэр орноо авч явах зэрэг үйл явц ажиглагдаж байгаа бөгөөд тэдгээрийн ирээдүйн амьдралын баталгаа алдагдаж, ирээдүйн ядуусыг бий болгодгоороо ядуурлын нөхөн үйлдвэрлэлийг бий болгож байна.

Тэдгээр хүүхдүүдэд бусдын адил сурч боловсрон өөрийн сонирхсон мэргэжлээ эзэмших сонголтыг огтхон ч олгохгүй байна. Тэд бага байхаасаа гадуурхагдаж, үүнээсээ болоод баян хүмүүсийг үзэн ядах эсвэл хэзээ ч баян болохгүй байх гэсэн гутранги хандлагаар төлөвшдөг. Тэд мэдээлэл мэдлэгээс хойно үлдэж аливаа зүйлд эелдэг, ухаалаг хандах, хүмүүстэй учир зүйгээ эвтэйхэн олох чадвар суугаагүйн дээр хөгжил дэвшлийн үр өгөөжийг огтхон ч хүртэхгүй байна. Иймээс харилцааны асар гүн ядууралд орж байгаа юм. Эндээс харахад орлогын ядуурал өөрөө бусад ядуурлын хэлбэр болох мэдлэг, мэдээллийн хомсдол, нийгмийн гол үйлчилгээ болон өөрийн чадавхийг өргөтгөх боломжийн ядуурал, харилцааны ядуурлыг үүсгэх маш том хүчин зүйл болж байна.

Ядуусын төлөөх хөгжлийн арга зам гэж юу вэ? Нэгэнт ядууралд өртсөн хүмүүст шууд төрөөс мөнгө өгснөөрөө эсвэл төрөөс бүхий л бололцоогоор хангах нь зохисгүй бөгөөд энэ нь тэднийг бэлэнчлэх сэтгэлгээнд сургаж цаашлаад хөдөлмөрийн ядуурлыг бий болгон ядуусын тоог нэмж ч болох юм. Харин төрөөс ядуусыг дэмжих төсөл, хөтөлбөрийн талаарх мэдээллээр сайн хангах, өөрсдөд нь ямар боломж байгааг сайтар таниулах, тусгай сургалт явуулах, үүний дараагаар тэднийг орхих бус өөрийн чадварт тохируулан өндөр цалинтай, төрийн болон хувийн байгууллагад гэрээ хийж, 1-2 хүнийг нэг газар ажиллуулах зэрэг боломжоор хангаж болох юм. Хамгийн гол нь энд хувийн хэвшлийнхэн төртэй сайтар хамтарч ажиллах бөгөөд ингэснээрээ ядуучуудыг зөнд нь хаяж ялгаварлан гадуурхах бус харин ч ажиллагсдын эгнээнд татан оруулж, өөрийн нөөц боломжийг нь мэдрүүлж, нийгмийн үйл хэрэгт оролцуулж, сэтгэлгээг эрүүлжүүлэх хэрэгтэй. Зарим улс оронд эцэг, эх хүүхдийнхээ тодорхой зайлшгүй хэрэгцээг хангаж чадахгүй бол улс хүүхдийн эрхийг зөрчсөн хэмээн үзэж, өөрийн асрамжинд авч эцэг эхээс нь холдуулдаг. Энэ туршилгыг Монголд ч хэрэгжүүлбэл зүйтэй юм. Мөн төр иргэдийнхээ бүртгэл мэдээллийн системийг сайжруулмаар байна. Ингэснээрээ бага орлоготой хүмүүс хаана хэрхэн амьдарч байгаа талаар судлан тэдгээрийн чадвар нөөц бололцоог ашиглах ямар төрлийн үйлдвэрлэл, салбарыг хөгжүүлэх вэ, мөн хэнд ямар боломжоор хангаж болох талаар иргэддээ түлхүү чиглэсэн макро эдийн засгийн бодлого боловсруулж болох юм. Ийм хэлбэрийн бодлогыг эдийн засагчид ядуусын төлөөх өсөлт хэмээн нэрийджээ(3). Ийм маягийн бодлогыг амжилттай хэрэгжүүлж ядуучуудын тоог эрс буулгаж чадвал эдийн засгийн өсөлт нь эргээд ядуусын төлөөх хөгжилд хүргэх юм.

Ашигласан материал

1. Намсрайн Батгасан, Селим Жахан, 2006. "Хүний хөгжил" сурах бичиг, Улаанбаатар
2. С.Баатар, 2007. "Баялаг ба ядуурлын тухай", МХАХН, ХАССТ, НҮХАС, Монголын хүн амын сэтгүүл, дугаар 16, Улаанбаатар
3. Монгол Улсын Засгийн Газар, НҮБХХ, 2004. Хүний Хөгжлийн Илтгэл 2003: Хот хөдөөгийн хүний хөгжлийн ялгаа, Улаанбаатар